

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.20 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам”-ыг нэгдүгээр, “Мэргэшлийн зэргийн үнэмлэх”-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Түмэндэмбэрэл/-т, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Т.Жамбалцэрэн)- т тус тус үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2020 оны .... дугаар сарын .... өдрийн .... дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## **МАЛЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь малын эмч мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, бүртгэх үйл ажиллагааг “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулахад оршино.

1.2.Мал эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох нь мэдлэг, ур чадварыг үнэлэх, баталгаажуулахад чиглэгдэнэ.

1.3.Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, бүртгэх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

1.4.Мэргэшлийн зэргийг хувийн хэвшилд ажиллаж буй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч мэргэжилтэнд шатлалын дагуу олгоно.

1.5.Мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон эх материал, мэдээлэл бусад холбогдох баримт бичгийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн санд бүртгэж, архивын нэгж болгон хадгална.

### **Хоёр. Мэргэшлийн зэргийн шатлал**

2.1.Мэргэшлийн зэрэг нь ахлах, тэргүүлэх, зөвлөх гэсэн 3 шатлалтай байна.

2.2.Ахлах зэрэгтэй малын эмч мэргэжилтэн нь журмын 3.1.1-д заасан мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлага хангасан, ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийн санал боловсруулах, шийдвэрлэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд сургалт, семинар удирдан явуулах, хичээл заах, зааварчлага өгөх, судалгаа шинжилгээ, туршилтын ажилд оролцох, тэдний хөгжилд хувь нэмэр оруулах ур чадвартай байна.

2.3.Тэргүүлэх зэрэгтэй малын эмч мэргэжилтэн нь журмын 3.1.1-д заасан мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлага хангасан, тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд сургалт, семинар удирдан явуулах, зааварчлага өгөх, судалгаа шинжилгээ, туршилтын ажлын тодорхой хэсгийг удирдах, шинэ залуу мэргэжилтнийг дагалдуулан сургах, дадлагажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний ашигтай загварын анхдагч саналд шүүлт хийх, дүгнэлт, үнэлгээ өгөх зэрэг ур чадвартай байна.

2.4.Зөвлөх зэрэгтэй малын эмч мэргэжилтэн нь журмын 3.1.1-д заасан мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлага хангасан, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулахад оролцох, санал дүгнэлт өгөх, үндэсний болон гадаад орон, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд ажиллах, албан ёсны дүгнэлт гаргах, шинжлэх ухаан, технологийн болон бизнес төсөл удирдах зэрэг ур чадвартай манлайлагч байна.

2.5. Зөвлөх зэрэгтэй малын эмч, мэргэжилтэн нь тусгай дугаар бүхий хувийн тэмдэгийг эзэмшинэ.

2.6.Мэргэшлийн зэргийн шатлалыг алгасуулан олгохгүй.

2.7. Мэргэшлийн зэрэг хоорондох шатлал ахиулах хугацаа 5 ба түүнээс дээш жил байна.

2.8. Тухайн малын эмч мэргэжилтний боловсрол, мэргэжлийн онолын түвшин, дадлага туршлага, зохион байгуулах чадвар, идэвх санаачилга, бүтээлч сэтгэлгээ, авьяас, чадавхийг шалган тогтоосны үндсэн дээр түүнд “Ахлах”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн мэргэшлийн зэргийг олгоно.

2.9. Гадаадын иргэн болон Монгол улсын харьяалалгүй иргэнд мэргэшлийн зэрэг дэв олгохгүй.

## Гурав. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур

### 3.1. Малын эмч, мэргэжилтэнд тавигдах шаардлага:

№	Горилж буй мэргэшлийн зэрэг	Мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлага	
1	Ахлах	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд /бакалавр, магистр/ боловсрол эзэмшсэн байх;
		Ажилласан жил	Бакалаврын зэрэгтэй бол 8 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
			Магистрын зэрэгтэй бол 5 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
		Бусад шаардлага	Тухайн мэргэжлээрээ мэргэшсэн байх;
Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;			
2	Тэргүүлэх	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд /бакалавр, магистр, доктор/ боловсрол эзэмшсэн байх;
		Ажилласан жил	Бакалаврын зэрэгтэй бол 13 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
			Магистрын зэрэгтэй бол 8 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
		Бусад шаардлага	Тухайн мэргэжлээрээ мэргэшсэн байх;
Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;			
3	Зөвлөх	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд /бакалавр, магистр, доктор/ боловсрол эзэмшсэн байх;
		Ажилласан жил	Бакалаврын зэрэгтэй бол 18 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
			Магистрын зэрэгтэй бол 15 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;
		Бусад шаардлага	Тухайн мэргэжлээрээ мэргэшсэн байх;
Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;			

## **Дөрөв. Мэргэшлийн зэрэг горилогчийн бүрдүүлэх баримт бичиг**

- 4.1. Мэргэшлийн зэрэг олгохыг хүссэн малын эмч, мэргэжилтний өргөдөл;
- 4.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.3. Аймаг, нийслэлийн мэргэжлийн байгууллагын дэмжсэн тодорхойлолт;
- 4.4. Малын их эмчийн мэргэжлийн дипломын хуулбар;
- 4.5. 3x4 хэмжээтэй зураг 2 хувь (сүүлийн 6 сард авахуулсан байх);
- 4.6. Мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлагыг хангасныг баталгаажуулах баримт бичиг;
- 4.7. Гарын авлага, зөвлөмж, ашигтай загварын гэрчилгээний хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/;
- 4.8. Дэд профессор, профессорын зэрэг олгосон үнэмлэхийг нотариатаар батлуулсан хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/;
- 4.9. Эрдмийн зэрэг цол хамгаалсан дипломын хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/

**Тав. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь мэргэшлийн зэргийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:**

- 5.1. Мэргэшлийн зэрэг олгох хэрэгжилтийг зохицуулах;
- 5.2. Хууль эрх зүйн орчинг сайжруулах санал боловсруулж, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;
- 5.3. Мэргэшлийн зэрэгтэй холбоотой цахим мэдээллийн санг ажиллуулах, боловсронгуй болгох, хяналт тавих;
- 5.4. Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, шийдвэрийг гаргах;
- 5.5. Мэргэшлийн зэрэг олгох ажиллагааг зохион байгуулах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 5.6. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгуулгаас ирүүлсэн малын эмч мэргэжилтний материалыг хянан магадлах, зэргийн шалгалтыг зохион байгуулах 5-7 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг томилох.
- 5.7. Мэргэшлийн зэргийг олгох үйл ажиллагааг зохион байгуулах комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.7.1. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;
  - 5.7.2. малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох шалгалтын хөтөлбөр, үргэлжлэх хугацаа, төлбөрийг урьдчилан боловсруулж, Мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын даргаар батлуулах;
  - 5.7.3. аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн мэргэшлийн зэргийн шалгалтад орох болзол хангасан малын эмч, мэргэжилтний бичиг баримтыг журмын дагуу хүлээн авч хянах;
  - 5.7.4. мэргэшлийн зэргийн шалгалтын комиссын дүнгийн хуудас, мэргэшлийн зэрэг горилогчийн хүсэлт, өргөдөл, гомдлын маягтыг баталгаажуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
  - 5.7.5. мэргэшлийн зэргийн шалгалтын дүнг үндэслэн малын эмч мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох санал боловсруулж, Мэргэжлийн зөвлөлд танилцуулан, Мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын даргын шийдвэрээр баталгаажуулах;
  - 5.7.6. мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг үндэслэн мэргэшлийн зэргийн үнэмлэхийг батлагдсан загварын дагуу хэвлүүлэн бичиж, баталгаажуулан, Аймаг нийслэлийн мал эмнэлгийн байгууллагуудад хүргүүлэх;

5.7.7.малын эмч, мэргэжилтэн, иргэн, бусад хуулийн этгээдээс мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;

5.7.8.мэргэшлийн зэрэгтэй холбоотой баримт бичгийг архивын хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэн хадгалах;

5.7.9.мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас даалгасан малын эмч мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй холбоотой бусад чиг үүрэг.

### **Зургаа. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага нь мэргэшлийн зэргийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

6.1.Мэргэшлийн зэрэгтэй малын эмч мэргэжилтний судалгааг зэрэг тус бүрээр, мэргэшлийн зэрэг шинээр горилох, шатлал ахиулах хүсэлт ирүүлсэн судалгааг жил бүр нэгтгэн гаргах;

6.2.Малын эмч мэргэжилтнийг мэргэшлийн зэргийн шалгалтын талаарх мэдээллээр хангах, төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын чиглэлээр сургалтын байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран сургалт зохион байгуулах;

6.3.Ажлын хэсгийг байгууллагын түвшинд томилж, тухайн жилд мэргэшлийн зэргийн шалгалт өгөх хүсэлт гаргасан малын эмч мэргэжилтний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, мэргэшлийн зэргийн шалгалтад орохыг дэмжсэн малын эмч мэргэжилтний бичиг баримтыг нэгдсэн журмаар Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагад уламжлах;

6.4.Мэргэшлийн зэргийн шалгалтын хугацаанд малын эмч мэргэжилтний үүрэгт ажлыг зохицуулах, дэмжлэг үзүүлэх;

### **Долоо. Малын эмч мэргэжилтэн нь мэргэшлийн зэргийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

7.1.Мэргэшлийн зэрэг горилох тохиолдолд харьяалах мал эмнэлгийн тасагт хүсэлт гаргаж, баталгаажуулах;

7.2.Бүрдүүлсэн бичиг баримт, нотолгоо, тайлан, хүсэлтийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

7.3.Мэргэшлийн зэргийн шалгалттай холбогдон гарах зардлыг өөрөө хариуцан төлөх.

### **Найм. Мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтын үйл ажиллагаа**

8.1.Журмын 3.1.1 дэх хэсгийн малын эмч, мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан малын эмч мэргэжилтний хүсэлтийг сум, дүүргийн Мал эмнэлгийн тасаг, холбогдох материалын хамт хүлээн авч аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

8.2.Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллага хүсэлтийг хүлээн авч шаардлага хангасан мэргэжилтний материалыг хянаж магадлан, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжлах.

8.3.Мэргэшлийн зэргийн сургалт болон шалгалтыг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны дотор жилд зөвхөн нэг удаа зохион байгуулна.

8.4.Мэргэшлийн зэрэг горилгогчдод мэргэшлийн зэргийн сургалт зохион байгуулж, шалгалт авна.

8.5. Сургалт зохион байгуулах байршил, хугацаа, мэргэшлийн зэргийн сургалт, шалгалтад орох эрх хангасан малын эмч мэргэжилтний нэрийг мэргэшлийн зэргийн сургалт, шалгалт эхлэхээс ажлын 14-өөс доошгүй хоногийн

өмнө Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахимаар болон мэдээллийн хэрэгслээр зарлана.

8.6.Мэргэшлийн зэргийн шалгалтыг мэргэжлийн сургалт хариуцсан байгууллага болон мэргэжлийн холбоод хамтран зохион байгуулж болно. Сургалтыг докторын зэрэгтэй профессор багш нар батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулна.

8.7.Мэргэшлийн “Багц” хичээлүүдээр “Ахлах” мэргэжилтэн 2 багц цаг, “Тэргүүлэх” мэргэжилтэн 3 багц цаг, “Зөвлөх” мэргэжилтэн 5 багц цагийг тус тус судлана.

8.8.Мэргэшлийн зэргийн шалгалт дараах үе шаттай явагдана. Үүнд:

8.8.1.шалгалтын бэлтгэл ажлыг хангах, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

8.8.2 шалгалтын комиссыг томилох;

8.8.3 шалгалт зохион байгуулах;

8.8.4 шалгалтын гүйцэтгэлийг дүгнэх, мэдээлэх;

8.8.5 шийдвэр гаргах;

8.8.6 шалгалттай холбоотой гомдол шийдвэрлэх.

8.9. Мэргэшлийн зэрэг олгох шалгалт нь ахлах зэрэг горилогчид зөвхөн нэг, зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилогчид хоёр хүртэл үе шаттай байна. Үүнд:

8.9.1.нэгдүгээр шат: мэргэшлийн мэдлэг, ур чадвар шалгах;

8.9.2.хоёрдугаар үе шат: салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, зааврын талаарх мэдлэгийг шалгах.

8.10. Ахлах зэрэг горилогч нь мэргэшлийн ур чадварын шалгалтад авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувь, зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилогч нь 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн бол тэнцсэнд тооцно.

8.11.Мэргэшлийн шалгалтыг бичгээр эсхүл тестээр авна.

8.12.Шалгалтын комисс нь малын эмч, мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл, туршлагыг ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн тайланг магадлан шалгах замаар тодорхойлно.

8.13.Эхний шатны шалгаруулалтад тэнцээгүй зэрэг горилогч нь дараагийн шатны шалгаруулалтад орох эрхгүй.

8.14.Шалгалтын комисс нь зэрэг горилогчийн шалгалтын дүн, бүтээл, туршлагад үндэслэн зэрэг олгох саналаа мэргэжлийн зөвлөлд танилцуулна.

8.15.Шалгалтын тест, бодлого, өгөгдлийг тестийн сангаас сонгох бөгөөд энэ нь шалгалт авах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

8.16.Зэрэг горилогчийн авсан онооны нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, дундаж оноог гаргах ба комиссын дарга энэ дүнг комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн гишүүн бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

8.17.Комиссын нарийн бичгийн дарга нь шалгалтын нэгдсэн дүн, холбогдох материалыг цэгцэлж шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор комиссын гишүүн бүрд хүргэж танилцуулан, хурлаар шийдвэрлүүлнэ. Шалгалтын үнэлгээн дээр маргаантай асуудал гарвал горилогч нь гомдол, саналаа мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах комисст бичгээр тавьж шийдвэрлүүлнэ. Энэ шийдвэр эцсийн шийдвэр байна.

8.18.Шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хянагчаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч хяналт тавьж болно.

8.19.Комиссын гишүүдэд нөлөөлөхийг оролдсон, горилогчийг үндэслэлгүй дэмжиж, бусдаас хэт зөрүүтэй үнэлгээ тавьсан гишүүнийг комисс хэлэлцэж, түүний үнэлгээг комиссын нэгдсэн дүнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

8.20.Мэргэшлийн зэрэг горилогч нь шалгаруулалтад тэнцээгүй бол дахин шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргасны үндсэн дээр тухайн жилд зөвхөн нэг удаа дахин шалгаруулалтад орж болно.

8.21.Мэргэшлийн зэргийн шалгалттай холбоотой дараах гомдлыг малын эмч, мэргэжилтнээс мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулсан комисст бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ:

- 8.21.1 шалгалтын бүртгэлтэй холбоотой гомдол;
- 8.21.2 комиссын гишүүн журам зөрчсөн тухай гомдол;
- 8.21.3 шалгалтын явцад гарсан зөрчилтэй холбоотой гомдол;
- 8.21.4 шалгалтын агуулга, хэлбэртэй холбоотой гомдол;
- 8.21.5 шалгалтын үнэлгээтэй холбоотой гомдол;
- 8.21.6 шалгалттай холбоотой бусад гомдол.

8.22.Гомдол гаргагч нь бүртгэлтэй холбоотой гомдлыг бүртгэл дууссанаас хойш ажлын гурав хоногт, шалгалтын явцад гарсан зөрчилтэй холбоотой гомдлыг шалгалт өгсөнөөс хойш ажлын нэг өдөрт, үнэлгээтэй холбоотой гомдлыг шалгалтын дүнг зарласан өдрийн ажлын цагт багтаан, бусад гомдлыг шалгалт дууссанаас хойш тав хоногийн дотор тус тус бичгээр ирүүлнэ.

8.23.Гомдол гаргагч нь үндэслэлээ тодорхой дурдаж, өөрийнхөө тавьж буй шаардлагын талаарх нотолгоо, бусад холбогдох баримтыг хавсаргана.

8.24.Шалгалтын комисс нь гомдлыг судлан хуулийн хугацаанд шуурхай шалгаж шийдвэрлэж, хариуг гомдол гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

### **Ес. Мэргэшлийн зэрэг олгох, бүртгэх**

9.1. Мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах комисс нь дийлэнх олонхийн /80.0%/ ирцтэйгээр хуралдаж, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг хэлэлцэж, санал хураалтаар дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэн протокол үйлдэнэ.

9.2.Уг протоколыг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар “Ахлах”, “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийн үнэмлэхийг олгоно.

9.3. Мэргэшлийн “Зөвлөх” зэргийн үнэмлэх, тэмдгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

9.4.Мэргэжлийн дагуу 25 ба түүнээс дээш жил ажиллан салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, салбарын хэмжээний хөтөлбөр, төсөл, хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичиг боловсруулсан, мал эмнэлгийн ухааны доктор (ph.D), шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Төрийн соёрхолт малын эмч, Монгол улсын гавьяат малын эмч, Хөдөлмөрийн баатар цолтой малын их эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлтээс үл хамааран, шалгалтгүйгээр зөвлөх зэргийг олгоно.

9.5. Энэхүү журмын 9.4-т заасан малын эмч, мэргэжилтэн нь хүсэлтээ мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шууд ирүүлнэ.

### **Арав. Мэргэшлийн зэргийг хүчингүй болгох, нөхөн олгох**

10.1.Тухайн чиглэлээр мэргэшлийн зэрэг олгосныг гэрчлэх баримт бичиг нь мэргэшлийн зэргийн үнэмлэх байна.

10.2.Малын эмч, мэргэжилтний мэргэшлийн зэрэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй байна.

10.3.Дараах тохиолдолд малын эмч мэргэжилтний мэргэшлийн зэргийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр хүчингүй болгоно. Үүнд:

10.3.1. мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.13 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь тогтоогдсон;

10.3.2. эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн.

10.4. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн бол мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр нөхөн олгоно.

10.5. Мэргэшлийн зэргийн үнэмлэх нөхөн олгох тохиолдолд малын эмч мэргэжилтэн дараах материалыг бүрдүүлэн, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргана:

10.5.1. мэргэшлийн зэргийн гэрчилгээг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл;

10.5.2. гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээг хэвлүүлэх бодит зардлын төлбөрийг төлсөн санхүүгийн баримт.

10.6. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг нөхөн олгож буй тохиолдолд шалгалтад орохгүй ба шинээр олгож буй үнэмлэхний баруун дээд хэсэгт “нөхөн олгов” гэж бичиж, олгоно.

10.7. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэх, бусдад дамжуулан ашиглахыг хориглоно.

### **Арван нэг. Бусад зүйл**

11.1. Мэргэшлийн зэрэг горилогчдын сургалтын төлбөр, мэргэшлийн зэргийн үнэмлэх, зөвлөх мэргэжилтний хувийн тэмдэг хийлгэх зардлыг тухайн малын эмч мэргэжилтний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, эсвэл хувь хүн өөрөө хариуцна.

11.2. Шалгалтын болон мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах комиссын зардалыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

### **Арван хоёр. Хариуцлага**

12.1. Энэхүү журмыг зөрчсөн Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шалгалтын комисс, малын эмч мэргэжилтэнд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Төсөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны...дугаар сарын...өдрийн .....тушаалын хоёрдугаар хавсралт

Байгууллагын бэлэгдэл

ЗӨВЛӨХ ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ

Үнэмлэхийн дугаар.....

Ургийн овог:

Эцэг/Эхийн нэр:.....Нэр:.....

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны...дугаар сарын...өдрийн.....тушаалаар “.....” зэргийг олгов.

ГАРЫН ҮСЭГ

Байгууллагын бэлэгдэл

..... ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ

Үнэмлэхийн дугаар.....

Ургийн овог:

Эцэг/Эхийн нэр:.....Нэр:.....

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны...дугаар сарын...өдрийн.....тушаалаар “.....” зэргийг олгов.

ГАРЫН ҮСЭГ

**“Нөхөн олгов”**

Байгууллагын бэлэгдэл

**ЗӨВЛӨХ ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ**

Үнэмлэхийн дугаар.....

Ургийн овог:

Эцэг/Эхийн нэр:.....Нэр:.....

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны...дугаар сарын...өдрийн.....тушаалаар “.....” зэргийг олгов.

**ГАРЫН ҮСЭГ**

**“Нөхөн олгов”**

Байгууллагын бэлэгдэл

..... **ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ**

Үнэмлэхийн дугаар.....

Ургийн овог:

Эцэг/Эхийн нэр:.....Нэр:.....

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны...дугаар сарын...өдрийн.....тушаалаар “.....” зэргийг олгов.

**ГАРЫН ҮСЭГ**